



# СОҮЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

143 /143/

2021.09.27

## ҮЙЛ ЯВДАЛ

### ОХУ-Д СУРАЛЦАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ҮДЭЖ МОРДУУЛЛАА



ОХУ-д цэргийн академи, их, дээд сургуульд суралцаж буй офицер, ахлагч нарын эхний хэсэг болох 130 орчим бүрэлдэхүүнийг үдэн гаргах ёслолын ажиллагаа өнөөдөр өглөө ҮБХИС-ийн байрлалд боллоо. Суралцагчдыг үдэж мордуулах ёслолын ажиллагаанд БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа С.Ванчинхүү,

ҮБХИС-ийн Сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очир болон эцэг, эхийн төлөөлөл оролцлоо.

1993 онд Монгол Улс, ОХУ-ын Батлан хамгаалах салбарын орчин цагийн харилцааны эхлэл тавигдаж Засгийн газар болон Батлан хамгаалах яам хооронд цэрэг, техникийн болон цэргийн хамтын ажиллагааны тухай

хэлэлцээр" байгуулагдаж 2007 оноос манай улсын цэргийн алба хаагчид хуучин ЗХУ-аас хойш анх удаа ОХУ-ын цэргийн академи, их, дээд сургуулиудад хөнгөлттэй нөхцөлөөр болон буцалтгүй тусламжийн суралцаж эхэлсэн билээ.

Жил бүр ОХУ-ын цэргийн академи, их, дээд сургуульд 50-100 орчим цэргийн алба хаагчийг

суралцуулахаар илгээж ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар батлан хамгаалах сайдын тушаалаар Зэвсэгт хүчин, Төрийн цэргийн байгууллагын төлөөлөл болох 340 гаруй цэргийн алба хаагч ОХУ-ын 14 хотод 30 гаруй цэргийн мэргэжлээр суралцах юм.

### БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫНХАН “ХОГГҮЙ БАЯНЗҮРХ” АЯНД НЭГДЛЭЭ



Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөгжлийн төвөөс “ХОГГҮЙ БАЯНЗҮРХ” бүх нийтийн их цэвэрлэгээний нэгдүгээр аяныг энэ сарын 25, 26-ны өдөр зохион байгуулж байна. “Хог хаягдлын тухай хууль”, “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын хүрээнд аж ахуй нэгж, иргэн нийтийн эзэмшлийн 50 метр хүртэлх талбай, гудамж, зам, гуу жалганд үүссэн хур хог хаягдлыг цэвэрлэх зорилготой уг аянг дэмжиж Батлан хамгаалах яам, ЗХЖШ, “Монгол цэргийн

нэгдсэн холбоо” ТББ болон Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг тус яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний ангиуд бүх нийтийн их цэвэрлэгээнд нэгдлээ. Батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүн хууль тогтоомжийн хүрээнд өөрсдийн харьяаллын болон нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэж, ил задгай хог хаягдлыг ангилж багасгасан нь коронавируст цар тахлын энэ үед оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо гэдгийг онцолсон юм.

### САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР

ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэг журам сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн хурал өнгөрсөн баасан гарагт боллоо. Хурлаар салбар зөвлөлийн гуравдугаар улирлын тайланг танилцуулж, 2010-2021 онд Зэвсэгт хүчний алба хаагчдаас шүүхээр хорих болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн цэргийн алба хаагчдын судалгаа, Зэвсэгт хүчний 2010-2021 онд дотоодод бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн тухай

танилцууллаа. Мөн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай ажилладаг салаа, салбарын офицер, ахлагч, нарт хөтлөгдөх хувийн хэрэг нээх маягтын загварыг танилцуулж, салбар зөвлөлийн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, гэмт хэрэг, осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар холбогдох удирдлагуудад үүрэг чиглэл өглөө.



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
289.227 +2184

ЭДГЭРСЭН  
297.485 +6933

НАС БАРСАН  
1133 +17

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
5202 +88

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
198

ЭДГЭРСЭН  
4609

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 232,595,152

Эдгэрсэн  
Нийт: 209,218,574

Нас барсан  
Нийт: 4,761,798

## Түүхэнд энэ өдөр

1939 он:

Зөвлөлт, Монголын болон Япон, Манж-Гогийн талаас байлдааны ажиллагааг зогсоож, нас барсан цэргүүдийн хүүр болон олзлогдсон хүмүүсийн биеийг харилцан солилцооор томилогдсон комисс олзлогдогсдыг солилцжээ.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
13	0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
30	13

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,343.0	3,355.0
CNY	441.00	441.08
RUB	38.20	39.40
JPY	25.58	26.02
KRW	2.38	2.47

## ЗУРХАЙ

2021.09.24 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 18/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР БАР ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингих:

06.46-18.41

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал:

Мод

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн.

Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлээдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.



цахим шууданд

## ДУРСГАЛЫН "СОЁМБО" ЦОГЦОЛБОР ҮҮДЭЭ НЭЭЛЭЭ



Монгол Улсын төр, цэргийн зүтгэлтэн, БХЯ-ны сайд, ЗХЖШ-ын дарга агсан хурандаа генерал Ж.Ёндонгийн хөшөө, дурсгалын "Соёмбо" цогцолбор Сүхбаатар аймгийн баруун-урт хотноо сүндэрлэн бослоо.

Тус цогцолбор нь хурандаа генерал Ж.Ёндонгийн алдар гавьяаг мөнхжүүлэх, Зэвсэгт хүчний 100 жилийн хөгжил цэцэглэлтийг олон нийтэд сурталчлан таниулахад хувь нэмрээ оруулсан нэгэн томоохон ажил болж байгаа юм.



## "АФГАНИСТАНЫ ТУРШЛАГА, СУРГАМЖ" ЦУВРАЛ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



БХЭШХ "Афганистаны туршлага, сургамж" сэдэвт тусгай төлөвлөгөө гарган 8 үндсэн ажлыг хэрэгжүүлж энэ хүрээнд "Афганистаны туршлага, сургамж" цуврал хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулж явууллаа.

Тус хэлэлцүүлгийг энэ сарын 15-нд УАБЗ-ийн Ажлын алба, ЗХЖШ-ын ЭДА-ны хэлтэс болон Афганистанд сургалтын болон аюулгүй байдал, харуул хамгаалалтын чиглэлээр үүрэг гүйцэтгэсэн цэргийн багуудын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан юм. Үүнд,

1. Тогтвортой эрх чөлөө ажиллагаа;
2. NATO-TM-Нисдэг тэрэгний сургалтын баг;
3. NATO-TM-Артилерын сургалт;
4. ISAF-АНУ-ын тэргүүлсэн цэргийн ажиллагаа;
5. ISAF-ХБНГУ-ын тэргүүлсэн цэргийн ажиллагаа;

6. ISAF-Бельги Улсын Зэвсэгт хүчинтэй хамтарсан цэргийн ажиллагаанд 2003-2021 онд үүрэг гүйцэтгэсэн 10000 орчим ЦАХ-ийг төлөөлж 8 багийн удирдлага туршлага, сургамжаа хуваалцлаа.

Уг хэлэлцүүлгээр эвслийн цэргийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн багуудын туршлага, сургамжийг хуваалцаж энэ чиглэлээр цаашид эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүнзгийрүүлэх шаардлага хэрэгцээ байна гэж дүгнэн БХЭШХ-ийн төвүүд судалгааныхаа үндсэн чиглэлээр тандалт

хийж байна. Тухайлбал, Цэргийн урлаг судлалын төв "Афганистанд явагдсан байлдааны ажиллагааны туршлага, сургамж" сэдэвт салбарын судалгааны ажлыг явуулах саналаа БХЯ-ны ШУТЗ-д хүргүүлээд байна. Мөн сургалт бэлтгэлийг сайжруулах боломж, өнөөгийн мөрдөгдөж байгаа Монгол Улсын цэргийн дүрмүүд, түүнтэй холбогдох журам, зааврыг шинэчлэн тогтоох хэрэгцээ зэрэг асуудлыг хөндөж судлахаар бэлтгэл ажил хангаж байна. Мөн төлөвлөгөөний дагуу "Афганистаны туршлага, сургамж" II хэлэлцүүлгийг 2021 оны энэ сарын 24-нд УАБЗ-ийн Ажлын алба, ЗХЖШ-ын БСТГ, ЭДАХ, УБХИС-ийн ЦНДС-тай хамтран зохион байгуулав. Уг хэлэлцүүлгээр;

1. Исламын Бүгд Найрамдах Афганистан улсын /Афганистаны/ нийгэм, улс төрийн түүхэн уламжлал;
2. Афганистаны аюулгүй байдлын гадаад, дотоод орчны үнэлгээ;
3. Афганистанд явагдсан байлдааны ажиллагааны онцлогууд, цэргийн урлагийн хөгжилд нөлөөлсөн байдалд хийсэн судалгаа;
4. Афганистан дахь олон улсын цэргийн ажиллагаанд оролцсон Монголын цэргийн багийн сэтгэл зүйн бэлтгэл, хангалтыг зохион байгуулсан байдал, үр дүн, туршлага, сургамж;
5. Афганистан

дахь олон улсын цэргийн ажиллагаанд оролцсон Монголын цэргийн багийн сургалт, бэлтгэлийг зохион байгуулсан байдал, үр дүн, туршлага, сургамж;

6. Афганистанд явагдсан олон улсын цэргийн ажиллагаанд ашиглаж байсан цэргийн зэвсэглэл, техник хэрэгслийн талаарх судалгаа зэрэг асуудлаар БХЭШХ-ийн эрдэмтэн судлаачид болон УБХИС-ийн ЦНДС-ийн судлаач багш илтгэл хэлэлцүүлж, санал бодлоо хуваалцлаа.

Хэлэлцүүлгийн мөрөөр бүс нутгийн төдийгүй олон улсын тавцанд аюулгүй байдлын олон талт асуудлын эх үүсвэр болж байгаа шашин, итгэл үнэмшилтэй холбоотойгоор судалгааны ажлыг явуулах хэрэгцээ, шаардлага байна гэж судлаачид дүгнэлээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчин Афганистанд 18 жил үүрэг гүйцэтгэхдээ хуримтлуулсан цэргийн ажиллагааны туршлага сургамж арвин байна. Энэхүү туршлага сургамжийг хуваалцах, энэ мөрөөр эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх нь Монгол Улсын ЗХ-ний бие бүрэлдэхүүний бэлтгэлжилт, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, цаашлаад цэргийн шинжлэх ухааны судлалд хувь нэмэр оруулах, цэргийн болон төрийн бодлого тодорхойлогчдын шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Дэд хурандаа Т.МӨНХ-ОРГИЛ

## ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ СУРГАЛТ БОЛОВ



### Булган аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Батлан хамгаалахын сайдтай, аймгийн Засаг даргын 2021 онд хамтран ажиллах гэрээ, Цэргийн штабын 2021 оны "Цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэх алба хаагчдын "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл" шатны сургалтыг аймгийн Засаг даргын 2021 оны А/351 захирамжийн дагуу 2021 оны 9

дүгээр сарын 10-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийг түшиглэн зохион байгууллаа. Сургалтад хамрагдаж байгаа бие бүрэлдэхүүнийг түргэвчилсэн шинжилгээнд бүрэн хамруулж, Улсын Онцгой комиссын заавар, зөвлөмжийн дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахиж зохион байгууллаа.

Цэргийн штаб Зэвсэгт хүчний 234 дүгээр

ангитай хамтран зохион байгуулж, тус ангийн багшлах бүрэлдэхүүн, сургалтад шаардагдах үзүүлэн таниулах материал хэрэгслийг түшиглэн явуулав.

Сургалт явуулахад цэргийн анги, байгууллагын мэргэжлийн офицер, ахлагч багш нарын мэдлэг чадварыг ашигласан нь сургалтын чанарт сайн нөлөө үзүүлээ. Онолын болон дадлагын хичээлүүдийг зааж, сургалтын төгсгөлд шалгалт авлаа.



## АЖЛЫН БАЙРНЫ АНХАН ШАТНЫ СУРГАЛТ ЯВУУЛЛАА



### Зэвсэгт хүчний 337 дугаар анги

УБХИС-ийг төгсөж тус ангид томилогдсон цэргийн алба хаагчидтай ангийн 2020-2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу ангийн захирагчийн тушаалын дагуу ажлын байрны анхан шатны сургалтыг ангийн байрлалд зохион байгууллаа.

Сургалтаар шинээр томилогдсон цэргийн алба хаагчдад Монгол Улсын Батлан хамгаалах салбарын багц хуулиуд, цэргийн нийтлэг дүрмүүдийг судлуулж, цэргийн алба, өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулан, байлдааны болон тайван цагийн цэргийн удирдлагыг хэрэгжүүлэх арга зүйг эзэмшүүлэх талаар

батлагдсан хичээлийн хөтөлбөр, конспектийн дагуу сургалт явуулсан.

Сургалтын эхэнд түвшин тогтоох шалгалт авч, бие бүрэлдэхүүний түвшинг тогтоон сургалтын төгсгөл, төгсөлтийн шалгалт авч, ангийн удирдлагаас шинэ төгсөгч нарт ажлын амжилт хүсэж, үүрэг даалгавраар хангалаа.